

БАТЛАВ
БУЛГАН АЙМГИЙН СОЁЛ УРЛАГ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН
ГАЗРЫН ДАРГА, Г.АЛДАРМӨНХ

**“БҮХ НИЙТИЙН СОЁЛЫН БОЛОВСРОЛ НИЙГМИЙН ХАРИЛЦААНЫ СОЁЛЫГ
ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЗОРИЛТОТ КОНТЕНТ БҮТЭЭЛГЭХ АЖЛЫН
ДААЛГАВАР**

2024 оны 11 сарын 18 өдөр

№

Булган

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Соёлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.12 дахь заалт, Монгол Улсын Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Булган аймгийн Засаг дарга нарын 2024 онд хамтран ажиллах гэрээний 2.2, Бүх нийтийн соёлын боловсрол олгох 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд зорилтот контент бүтээлгэх.

ХОЁР. ЗОРИЛГО

Бүх нийтэд соёлын боловсрол олгох, нийгмийн харилцааны соёл, төлөвшлийг бий болгох, хамтаараа амьдрах соёлыг олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан хүргэхэд оршино.

ГУРАВ. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

Булган аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар

ДӨРӨВ. КОНТЕНТЫН АГУУЛГА

- Олон нийтийн газар, төрийн байгууллагууд болон үйлчилгээний байгууллагуудад хүмүүсийн нийтлэг гаргадаг хүний эрхийн мэдрэмжгүй, соёлгүй үйлдлүүд нь бусдыг бухимдуулж, төвөг удаж, өөрийг нь ч таагүй харагдуулдаг. Тэдгээр үйлдүүдийг давтан гарахаас сэргийлэх, нийгмийн соёл төлөвшлийг бий болгох зорилгоор Төрийн байгууллагуудад гардаг мэдрэмжгүй үйлдлүүд, олон нийтийн газар соёлтой үйчлүүлэх, нийтийн гудамж талбайд соёлтой байх, автомашины зогсоолыг соёлтой ашиглах, нийтийн орон сууцанд бусдад төвөг удахгүй амьдрах гэх мэт... агуулгын хүрээнд 4 цуврал контент бэлтгэх

ТАВ. КОНТЕНТЫН ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

№	Агуулга	Үзүүлэлт
1	Дүрс бичлэгийн чанар	Full HD 1920-1080 доошгүй эсвэл 4K формат
2	Өргөтгөл	MP4

3	Ашиглах дүрс бичлэг <i>/анхаарах!/ </i>	<ul style="list-style-type: none"> - Youtube, Facebook, Vimeo, Spolity, бусад сошиал платформиос зориулалтын бус аргаар татаж авсан дуу, дүрс ашиглахгүй байх. - Зохиогчийн эрхийн аливаа зөрчилгүй гүйцэтгэх
4	Нэмэлт элемент	<ul style="list-style-type: none"> - Булган аймгийн лого - Булган аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын лого

ЗУРГАА. КОНТЕНТ БЭЛТГЭЖ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ, ХУГАЦАА

Бүх нийтийн соёлын боловсрол нийгмийн харилцааны соёлыг дээшлүүлэх чиглэлээр 4 цуврал зорилтот контентийн зохиолыг гүйцэтгэгч тал захиалагч талд урьдчилан танилцуулж гэрээнд заасан хугацаанд чанартай хийж гүйцэтгэн захиалагч байгууллагын мэдэлд бүрэн шилжүүлнэ. *Wetransfer татаж авах линкийг тогтсон хугацаанд багтааж ирүүлэх, мөн хугацаанаас өмнө ирүүлж болно/*